



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/403

Чингис хот

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, 10.1.8 дахь заалтууд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархаад буй 9 сумын 30.0 мянган га бэлчээрийн талбайд “Энгийн механик, биологийн” аргаар мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай “Энгийн механик, биологийн” аргаар тэмцэх талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчид, малчдын бүлэг хоршоо, сумын мэргэжлийн ангийг хамруулж, мэрэгчтэй тэмцэх ажлын гарын авлага шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, сургалт явуулах бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж, ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж, мэрэгчтэй тэмцэх ажилд ажиллах хүчийг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан)-т, уг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож дүгнэлт гаргаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ)-т тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын гүйцэтгэлийн үр дүнг холбогдох байгууллагад мэдээлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011946

Аймгийн Засаг даргын 2021 оны
...08 дугаар сарын 27 өдрийн А/УОС
дугаар захирамжийн хавсралт

ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Тэмцэх талбай /мян.га/
Үлийн цагаан оготнотой тэмцэх багаж тоног төхөөрөмж олгосон сумд орон нутгийн төсвийн хөрөнгөөр тэмцэх ажлыг зохион байгуулах		
1	Баянхутаг	2000
2	Галшар	2000
3	Баянмөнх	2000
4	Дархан	2000
5	Дэлгэрхаан	2000
Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулах		
6	Жаргалтхаан	4000
7	Батноров	6000
8	Баян-Овоо	6000
9	Норовлин	4000
	Дүн	300000